









АГУУЛГА

-  Бүртгэлтэй ажилгүйчүүд
-  Эрүүл мэнд
-  Банк
-  Төсөв
-  Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ
-  Хөдөө аж ахуй
-  Аж үйлдвэр
-  Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 01 дүгээр сарын байдал)

Бүртгэлтэй ажилгүй иргэн

Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 1 дүгээр сарын эцэст 727 байгаа ба 353 (48.6%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 13 (1.8%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба бүгд эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэд



2020 оны 1 дүгээр сард ажилгүй 307 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 99 иргэн ажилд зуулчлагдан орж, 544 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг сургууль төгссөн иргэд 15.9хувь нь, хамгийн бага хувийг өөр газраас шилжиж иргэд буюу 2.3 хувь нь эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 56.3 хувийг бүрэн дунд, 21.9 хувийг дипломын болон бакалаврын дээд, 9.1 хувийг техник мэргэжлийн, 5.6 хувийг суурь, 4.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.4 хувийг бага, 1.6 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 61.2 хувийг 15-34 насны залуучууд, 33.4 хувийг 35-54 насныхан, 5.4 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2020 оны 1 сарын эцэст




Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2020 оны эхний 1 сарын эцэст



Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 1 сарын байдлаар 101 эх амаржиж, 101 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 18 (15.1%-аар, амьд төрсөн хүүхэд 18 (15.1%-аар тус тус нэмэгдсэн байна.




Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2020 оны эхний 1 сард 3 болж, өмнөх оны мөн үеэс 2 (40%)-аар буурч, тав хүртэлх настай хүүхдийн эндэгдэл гараагүй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 26 болж, өмнөх оны мөн үеэс 1 (4%)-аар буурсан байна. Нийт халдварт өвчний 69 хувийг бэлгийн замын халдварт өвчлөл, сүрьеэ 12 хувийг, бусад халдварт өвчлөл 19 хувийг эзэлж байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 1 сарын байдлаар




Халдварт өвчний төрлөөр 2019 оны 1 сарын байдлаар



ТӨСВИЙН ОРЛОГО

Орон нутгийн төсөвт нийт 658.9 сая төгрөг бүрдэж, төлөвлөгөө 126.8 хувиар, үүнээс татварын орлого 588.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 129.3 хувиар, татварын бус орлого 70.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 108.4 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Аймгийн төсөвт байгууллагууд авлагагүй, 25.6 сая төгрөгийн өглөгтэй байна.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, мянган төгрөгөөр 2020 оны I сард



Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.7 хувь, өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр,			
Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020-01 2019-01	2020-01 2019-12
Ерөнхий индекс	100.0	104.7	100.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	103.1	100.7
Согтууруулах ундаа, тамхи	3.2	104.1	100.3
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.2	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	106.7	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.8	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	102.9	100.1
Тээвэр	12.2	100.3	100.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	98.2	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	118.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	126.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	102.2	100.1

Ерөнхий индекс 2020 оны 01 дүгээр сард мөн үеэс 4.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 3.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлш бүлгийн индекс 6.7 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн индекс 18.6 хувь, гэр ахуйн тавилга, бараа бүлгийн индекс 6.9 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн индекс 26.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Банк

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 01 сард 130.3 тэрбум төгрөг байгаа ба 0.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харицахын үлдэгдэл 2020 оны 01 сард 17.6 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 10.2 тэрбум буюу 57.9 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 01 сард 90.2 тэрбум төгрөгт хүрчээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ


(Сая төгрөг, тоогоор)

	Үзүүлэлт	Үлдэгдэл
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	130,317.9
	Үүнээс: <i>Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл</i>	895.1
	<i>Чанаргүй зээлийн үлдэгдэл</i>	1,017.7
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	17,594.0
	Үүнээс: <i>Иргэдийн харилцахын үлдэгдэл</i>	10,199.4
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	90,230.5
	<i>Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл</i>	89,056.2
	Үүнээс: <i>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</i>	18,299.1
	<i>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</i>	71,931.5
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	45
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	194
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	22685
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	112043
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	52391
	Нийт АТМ-ны тоо	21
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	44505

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр сарын байдлаар төллөх насны 1524.9 мянган хээлтэгч малын 0.9 мянга буюу 0.06 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 0.01 хувь, эм хонины 0.2 хувь, ингэний 0.01 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 94.7 хувь буюу 0.8 мянган төл бойжиж байна.

Том малын зүй бусын хорогдол 2020 оны 1 дүгээр сард аймгийн хэмжээнд 1114 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 273 толгой буюу 32.4 хувиар өссөн байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 18, үхэр 5, хонь 269, ямаа 822 байна. Нийт хорогдлын 24.1 хувийг хонь, 73.7 хувийг ямаа эзэлж байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ


Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2020 оны 1 дүгээр сард аймгийн төв буюу Есөнбулаг суманд ноолуур 55.0 мянган төгрөг, тэмээний шир 12.0 манган төгрөг, адууны шир 8.0 манган төгрөг, үхрийн шир 4.0-8.0 манган төгрөг, хонины арьс 2000 төгрөг, ямааны ноолууртай арьс 30.0 мянган төгрөг байна.

Говь-Алтай аймгийн 2020 оны I-II сарын цаг агаарын урьдчилсан төлөв

Есөнбулаг сумын агаарын төлөв байдлын тойм

2020 оны 2 дугаар сарын 10-наас 2 дугаар сарын 14 хүртэлх агаарын чанарын шинжилгээний дүнг өмнөх 7 хоногийн дундаж дүнтэй харьцуулахад агаар дахь хүхэрлэг хийн агууламж $0,012\text{мг}/\text{м}^3$ багассан, азотын давхар ислийн агууламж $0,009\text{мг}/\text{м}^3$ багассан байна. Хотын хэмжээнд агаар дахь хүхэрлэг хийн арав хоногийн дундаж агууламж $0,032\text{мг}/\text{м}^3$, хамгийн их агууламж $0,139\text{мг}/\text{м}^3$, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж $0,033\text{мг}/\text{м}^3$, хамгийн их агууламж $0,061\text{мг}/\text{м}^3$ -д хүрч АЧС-аас/ агаарын чанарын стандарт/ давсан тохиолдол ажиглагдаагүй байна.

Хэмжилтийн дүнг графикаар авч үзвэл бага бохирдолтой байлаа.



Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

мян.мөз thous.tug

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
НИЙТ ОРЛОГО		519695.7	658875.8	126.8
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН				
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ		0.0	0.0	0.0
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ		0.0	0.0	0.0
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН		0.0	0.0	0.0
ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ		0.0	0.0	0.0
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		519695.7	658875.8	126.8
1. ТАТВАРЫН ОРЛОГО		455051.6	588210.4	129.3
1.1 Орлогын албан татвар		406814.2	538375.8	132.3
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар		406814.2	538375.8	132.3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		303752.2	326802.6	107.6
Үйл ажиллагааны орлого		15962.0	41655.6	261.0
Хөрөнгийн орлого		80690.0	168376.4	208.7
Хөрөнгө борлуулсны орлого		0.0	0.0	0.0
Шууд бус орлого		6410.0	1541.2	24.0
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	0.0	0.0
1.2 Хөрөнгийн албан татвар		6499.1	12630.8	194.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		5000.0	2967.2	59.3
Галт зэвсгийн албан татвар		1260.0	1442.0	114.4
татвар		239.1	8221.6	3438.6
Малд ногдуулах албан татвар		0.0	0.0	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж		41738.3	37203.8	89.1
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж		21821.3	26592.3	121.9
Улсын тэмдэгтийн хураамж		11694.3	15895.4	135.9
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		-2000.0	0.0	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		0.0	1094.0	0.0
Хог хаягдлын хураамжийн төлбөр		12127.0	9602.9	79.2
1.3.2 Газрын төлбөр		16917.0	3791.9	22.4
Үүнээс: Газрын төлбөр		16917.0	3791.9	22.4
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		0.0	0.0	0.0
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		3000.0	6819.6	227.3
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		3000.0	6819.6	227.3
Байгалийн ургамал ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
1.3.4 Бусад татвар		0.0	0.0	0.0
2. Татварын бус орлого		64644.1	70065.4	108.4
Хүү, торгуулийн орлого		64225.0	62288.6	97.0
Төсвийн байгууллагын өөрийн орлого		0.0	0.0	0.0
Түрээсийн орлого		419.1	725.8	173.2
Бусад орлого		0.0	7051.0	0.0
3. Хөрөнгийн орлого		0.0	600.0	0.0
Өмч хувьчлалын орлого		0.0	600.0	0.0
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		70210.0	115224.5	164.1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		8000.0	9466.9	118.3
НӨАТатвар		58500.0	103076.7	176.2
Онцгой албан татвар		1500.0	2000.0	133.3
Агаарын бохирдлын төлбөр		1000.0	680.9	68.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		1200.0	0.0	0.0
Ус бохирдуулсны төлбөр		10.0	0.0	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ **сумаар**
PERFORMANCE REVENUE **soum**

мян.төг thous.tug

№	Сум	Soum	Нийт орлого		Хувь Rate
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	
1	Есөнбулаг	Yesunbulag	84,100.0	118,513.0	97.6
2	Алтай	Altai	3,030.0	7,030.7	104.6
3	Баян-Уул	Bayn-Uul	3,900.0	11,644.2	123.1
4	Бигэр	Biger	2,986.0	7,207.7	156.5
5	Бугат	Bugat	3,300.0	5,225.6	142.3
6	Дарив	Dariv	3,615.0	6,585.6	113.6
7	Дэлгэр	Delger	1,970.0	5,447.3	130.6
8	Жаргалан	Jargalan	3,713.3	5,857.0	143.7
9	Тайшир	Taishir	637.0	2,969.9	116.3
10	Тонхил	Tonhil	6,580.0	12,754.9	150.0
11	Төгрөг	Tugrug	3,790.0	7,692.5	114.9
12	Халиун	Khaliun	1,537.0	3,400.0	133.2
13	Хөхморьт	Khukhmorit	2,335.0	3,500.9	111.3
14	Цогт	Tsogt	2,780.0	10,023.0	106.5
15	Цээл	Tseel	3,800.0	12,429.7	117.5
16	Чандмань	Chandmani	2,743.0	6,863.2	123.6
17	Шарга	Sharga	2,390.0	5,965.3	129.6
18	Эрдэнэ	Erdene	3,412.0	8,036.8	182.0
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	1,030.0	877.2	143.7
20	Гуулин тосгон	Guulin	56.1	3,193.6	182.0
21	Татварын хэлтэс	Straight communicant	381,991.3	413,657.7	111.6
	Дүн		519,695.7	658,875.8	112.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, сумаар READING OG YOUNG ANIMALS, by type, soums

Сум	Төллөсөн хээлтэгч						Гарсан төл					
	Бүгд	Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Бүгд	988	0	0	1	924	63	988	0	0	1	924	63
Есөнбулаг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Алтай	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Уул	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бигэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дарив	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дэлгэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Жаргалан	20	0	0	0	0	20	20	0	0	0	0	20
Тайшир	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тонхил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Төгрөг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Халиун	63	0	0	1	19	43	63	0	0	1	19	43
Хөхморьт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цогт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цээл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Чандмань	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Шарга	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эрдэнэ	905	0	0	0	905	0	905	0	0	0	905	0

ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, сумаар READING OG YOUNG ANIMALS, by type, soums

Сум	Хорогдсон төл						Бойжсон төл					
	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Бүгд	52	0	0	0	30	22	936	0	0	1	894	41
Есөнбулаг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Алтай	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Уул	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бигэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дарив	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дэлгэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Жаргалан	5	0	0	0	0	5	15	0	0	0	0	15
Тайшир	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тонхил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Төгрөг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Халиун	17	0	0	0	0	17	46	0	0	1	19	26
Хөхморьт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цогт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цээл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Чандмань	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Шарга	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эрдэнэ	30	0	0	0	30	0	875	0	0	0	875	0

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, төрлөөр, сумаар LOSSES OG ADULT ANIMALS, by type, soum

Сум	Хорогдсон том мал						Өвчнөөр хорогдсон том мал						Хорогдсон хээлтэгч мал					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Бүгд	1114	18	5	0	269	822	15	2	1	0	3	9	264	2	1	0	75	186
Есөнбулаг	521	10	0	0	164	347	13	1	0	0	3	9	220	2	0	0	64	154
Алтай	6	1	0	0	2	3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Уул	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бигэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дарив	42	1	1	0	0	40	2	1	1	0	0	0	11	0	1	0	0	10
Дэлгэр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Жаргалан	365	0	4	0	52	309	0	0	0	0	0	0	8	0	0	0	3	5
Тайшир	62	2	0	0	12	48	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тонхил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Төгрөг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Халиун	42	0	0	0	6	36	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөхморьт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цогт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цээл	16	0	0	0	8	8	0	0	0	0	0	0	10	0	0	0	3	7
Чандмань	30	0	0	0	15	15	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Шарга	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эрдэнэ	30	4	0	0	10	16	0	0	0	0	0	0	15	0	0	0	5	10

ХӨДӨӨ АЖ АЖУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, 1 сар
 AVERAGE MARKET PRICE OF AGRICULTURAL PRODUCTS, by soum 1 month

Төрөл		Есөнбулаг	Алтай	Баян-Уул	Бигэр	Бугат	Дарив	Дэлгэр	Жаргалан	Тайшир	Тонхил	Төгрөг	Халиун	Хөхморьт	Цогт	Цээл	Чандмань	Шарга	Эрдэнэ
Буур	1	1000000	1300000	1200000	1500000	1200000	1300000	1100000	1500000	1200000	1000000	1000000	2000000	1100000	1000000	1500000	1200000	1300000	1000000
Ат (5 нас)	2	1000000	1000000	1200000	1200000	1000000	750000	950000	1000000	1000000	900000	900000	1500000	1000000	1000000	1300000	1200000	1300000	950000
Ингэ (5 нас)	3	800000	800000	900000	800000	900000	600000	950000	800000	800000	700000	700000	1200000	800000	950000	1100000	800000	1000000	900000
Эр шилбэ (3 нас)	4	600000	600000	500000	700000	700000	550000	900000	500000	600000	700000	550000	800000	700000	500000	700000	600000	800000	600000
Эм шилбэ (3 нас)	5	600000	600000	500000	700000	600000	550000	900000	500000	600000	600000	450000	800000	700000	500000	700000	600000	800000	600000
Эр ботго	6	400000	400000	300000	250000	400000	300000	250000	400000	300000	200000	200000	350000	300000	400000	500000	400000	500000	200000
Эм ботго	7	400000	400000	300000	250000	400000	300000	250000	400000	300000	200000	200000	350000	300000	400000	500000	400000	500000	200000
Азарга	8	1000000	1000000	1000000	1500000	1000000	1500000	1500000	850000	1000000	1000000	1200000	2000000	950000	1500000	1700000	1200000	1000000	900000
Соёолон үрээ (4 нас)	9	800000	800000	800000	800000	800000	700000	1000000	900000	600000	900000	800000	1000000	900000	1200000	900000	800000	900000	800000
Соёолон гүү (4 нас)	10	800000	800000	700000	700000	700000	600000	1000000	700000	600000	700000	500000	1000000	850000	1300000	800000	600000	750000	800000
Шүдлэн үрээ (2 нас)	11	500000	600000	500000	600000	600000	400000	900000	600000	400000	600000	600000	900000	700000	850000	700000	500000	500000	650000
Шүдлэн байдас (2 нас)	12	500000	600000	500000	600000	500000	400000	900000	600000	400000	500000	300000	800000	650000	850000	650000	500000	500000	650000
Эр унага	13	300000	250000	200000	250000	300000	150000	250000	400000	250000	250000	300000	350000	250000	500000	280000	200000	300000	200000
Эм унага	14	300000	250000	200000	250000	300000	150000	250000	400000	250000	250000	300000	350000	250000	500000	280000	200000	300000	200000
Бух	15	1000000	1000000	1000000	1200000	1000000	1300000	1200000	1200000	1000000	1000000	1500000	1500000	1000000	1200000	1100000	900000	1200000	1000000
Хязгаалан гуна (3 нас)	16	900000	800000	600000	900000	800000	500000	1000000	900000	800000	900000	900000	1000000	800000	1000000	1000000	800000	800000	950000
Хязгаалан гунж (3 нас)	17	600000	800000	600000	700000	600000	450000	1000000	900000	800000	700000	850000	700000	750000	1000000	950000	650000	800000	900000
Эр бяруу (1 нас)	18	350000	500000	250000	400000	600000	300000	350000	450000	450000	300000	550000	350000	500000	700000	500000	500000	350000	250000
Эм бяруу(1 нас)	19	350000	500000	250000	400000	500000	300000	350000	450000	450000	300000	550000	350000	500000	700000	500000	500000	350000	250000
Эр тугал	20	250000	250000	200000	200000	250000	150000	150000	350000	200000	250000	200000	250000	200000	400000	350000	250000	150000	150000
Эм тугал	21	250000	250000	200000	200000	250000	150000	150000	350000	200000	250000	160000	250000	200000	400000	350000	250000	150000	150000
Хуц	22	120000	180000	150000	150000	250000	250000	200000	150000	120000	150000	160000	230000	150000	200000	200000	150000	150000	150000
Эр хонь	23	150000	150000	150000	120000	150000	120000	150000	140000	150000	120000	150000	210000	150000	170000	160000	120000	180000	130000
Эм хонь	24	100000	100000	100000	100000	100000	80000	120000	80000	120000	80000	120000	130000	100000	110000	120000	100000	120000	100000
Эр төлөг	25	90000	80000	80000	80000	90000	60000	75000	70000	100000	80000	80000	130000	80000	80000	60000	60000	100000	85000
Эм төлөг	26	90000	80000	80000	80000	90000	60000	75000	70000	100000	80000	80000	120000	70000	80000	50000	60000	80000	85000
Эр хурга	27	50000	50000	40000	40000	40000	40000	25000	50000	30000	30000	30000	60000	30000	50000	40000	50000	50000	50000
Эм хурга	28	50000	50000	40000	40000	40000	40000	25000	50000	30000	30000	30000	60000	30000	50000	40000	50000	50000	50000
Ухна	29	150000	150000	150000	120000	150000	200000	120000	150000	100000	200000	130000	150000	120000	180000	170000	150000	150000	120000
Эр ямаа	30	100000	100000	100000	110000	110000	110000	100000	120000	120000	100000	110000	110000	100000	120000	120000	90000	120000	120000
Эм ямаа	31	70000	80000	65000	80000	70000	70000	90000	90000	80000	70000	60000	70000	80000	100000	70000	80000	80000	90000
Эр борлон	32	45000	60000	30000	50000	50000	50000	50000	50000	30000	45000	30000	40000	70000	60000	45000	30000	50000	70000
Эм борлон	33	45000	60000	30000	50000	50000	50000	50000	50000	30000	45000	30000	40000	50000	60000	45000	30000	50000	70000
Эр ишиг	34	25000	20000	25000	30000	25000	30000	35000	35000	20000	20000	20000	30000	25000	30000	20000	25000	30000	50000
Эм ишиг	35	25000	20000	25000	30000	25000	30000	35000	35000	20000	20000	20000	30000	25000	30000	20000	25000	30000	50000